



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

**2026 оны эхний хагас жилийн үйл
ажиллагааны бичмэл тайлан**

АГУУЛГА:

1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**1.1 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах дотоод ажлын
талаар**

1.2 Хүний нөөц

1.3 Өргөдөл, гомдлын талаар

1.4 Мэдээ, мэдээллийн чиглэлээр

2. САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

3. ТЭТГЭВРИЙН ТОГТООЛТ, ОЛГОЛТ


4. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

5. ХАМРАЛТ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ

6. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус газар нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/238 дугаар тушаалаар батлагдсан бүтэц, зохион байгуулалтаар нийт 58 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулахаас 58 байцаагч, ажилтантай үйл ажиллагаагаа явуулж, сар бүр орон тооны мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тайлагнаж ажилласан.



Албан хаагчдын нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, төрийн захиргааны албан хаагчид олгох зэрэг дэвийн нэмэгдэл олгох болон бусад судалгааг холбогдох хууль тогтоомжийн дагуу гарган НДЕГ-т хүргүүлсэн. **Тухайлбал:**

1. ГБХНХ-ын сайдын 2026.05.04 ний өдрийн А/86 дугаартай тушаалаар 6 алба хаагчийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийг хүргүүлж мөн болзол шаардлага хангасан 4 алба хаагчийг материалыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

2. УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолд заагдсан болзол шаардлага хангасан 19 албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв шинээр ахиулан олгуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

3. Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан Улсын байцаагчийн шалгалтад 13 алба хаагчийг хамруулснаас 5 албан хаагч тэнцэж, ГБХНХ-ын сайдын 2026.05.19 ний өдрийн А/92 дугаартай тушаалаар баталгаажсан.

4. НДЕГ-аас зохион байгуулсан Улсын байцаагчийн шалгалтад орох албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах зорилгоор НДЕГ-аас зохион байгуулсан 9 удаагийн сургалт болон дотооддоо зохион байгуулсан 3 удаагийн сургалтад бүрэн хамруулсан.

5. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем"-ийг турших, нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын хэмжээнд зохион байгуулалтын арга хэмжээ авч, 4 хэлтсийн 51 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахим системд бүрэн шивж оруулан, газрын даргаар баталгаажуулсан. Байгууллагын хэмжээнд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөлт, тайлагналтыг цахим хэлбэрт шилжүүлэх нэгдсэн системийн туршилт, нэвтрүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.

6. 2025 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 38 алба хаагч хуульд заасан хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгээ бүрэн гаргаж дуусгасан. Тайлан мэдээг тогтоосон хугацаанд НДЕГ-т хүргүүлэн ажилласан. 2026 оны эхний хагас жилийн байдлаар АТГ-т 4 алба хаагчийн ХАСУМ-ыг хянуулахаар хүргүүлж, ашиг сонирхлын зөрчилгүй дүгнэлтийг авсан.



**Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
дотоод ажлын талаар**

2026 оны эхний хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга)-ийг хэрэгжүүлэх болон бусад дотоод үйл ажиллагаатай холбоотой тушаал шийдвэр, заавар зөвлөмж, албан бичиг, ААНБ, иргэд даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл гомдол нийт UB ERP, E-Doc программаар 798 , ЭЙБЛ программаар 574, шуудангаар 65 ирснийг хэлтсүүдэд хүргүүлэн, албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж холбогдох тайлан мэдээ, судалгааг хуулийн хугацаанд гаргаж хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой дээд шатны байгууллагаас гаргасан 24 тогтоол шийдвэр, 2 албан даалгавар, НДЕГ-ийн даргын 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг тооцон, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Тус газрын даргын А тушаал 23, Б тушаал 38 гарсныг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

НДЕГ-ын даргын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөн ажиллаж тус газраар үйлчлүүлж буй иргэд даатгуулагчдад тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор иргэдийн үүдний хүлээлгийн танхимын хэсгийг засаж тохижуулсан. Тусгай хэрэгцээт иргэдэд чиглүүлэх зам, хонх байршуулж, ариун цэврийн өрөөг засаж, иргэдийг мэдээллээр хангах зорилгоор сургалт сурталчилгааны 2 лед дэлгэц байршуулан ажилласан. Иргэд даатгуулагчдыг тав тухтай үйлчлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлээд байна.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр гарган холбогдох газарт хүргүүлэн ажилласан. **2026 оны эхний хагас жилийн байдлаар:**

Нийт 297 өргөдөл гомдлыг хүлээн авснаас:


- Хугацаанд нь шийдвэрлэсэн 284,
- Судлагдаж байгаа 13,
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй.
- Шийдвэрлэлтийн дундаж хугацааны индекс 0.96 байна.

БИЧГЭЭР
291

11-11
төвөөс
6

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2026
ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



Агуулга:



“Callpro” дуудлагын үйлчилгээг хэрэгжүүлэн ажилласан ажлын талаар

Иргэд даатгуулагчдад үйлчлэх дуудлагын /callpro/ 7200-1289 / 501, 502, 503, 504, 505/ дугааруудын өдөр тутмын хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 3 удаагийн сүлжээний гэмтэл гарсныг “Колл про”ХХК-тай 72727-070 дугаарын утсаар холбогдон үйл ажиллагааг хэвийн болгосон. 7200-1289 /501, 502, 503/ дугааруудын дуудлагыг нэг цэгийн байцаагч, сайн дурын даатгалын байцаагч, тэтгэмжийн байцаагчийн гар утасны дугаартай нь холбон санал хүсэлтийг шуурхай хүлээн авч шийдвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2026 оны хагас жилийн байдлаар 54312 дуудлага хүлээн авч өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бүрэн шийдвэрлэн ажилласан.

 **CallPro**
54312



БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ЗАРЦУУЛАЛТ

2026 оны хагас жилийн байдлаар газрын үйл ажиллагааны зардалд 1,234,863.8 мянган төгрөг батлагдсанаас 1,234,000.0 мянган төгрөгийн зардлыг ангиллын дагуу зарцуулсан. Үүнд:

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 1,015,352.30 мянган төгрөг батлагдсанаас 1,015,352.3 мянган төгрөг

Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 124,919.50 мянган төгрөг зарцуулахаас 124,919.50 мянган төгрөг



Хангамж, бараа материалын зардалд 7,779.8 мянган төгрөг батлагдсанаас 7,779.8 мянган төгрөг

Эд хогшил, урсгал засварын зардалд 480.8 мянган төгрөг зарцуулахаас 480.8 мянган төгрөг

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 30,909.5 мянган төгрөг батлагдсанаас 30,900.0 мянган төгрөг

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 55,421.90 мянган төгрөг зарцуулахаас 54567.60 мянган төгрөгийг зардлыг зориулалтын ангиллын дагуу зарцуулсан.

САНГИЙН ЗАРДАЛД:

НДЕГ-ын даргын 2026 оны 06 дугаар сарын 05-ний өдрийн А/149 тоот тушаалын дагуу 269,817.80 сая төгрөгийн зардлаас зориулалтын дагуу 269,775.70 сая төгрөгийг зарцуулж, 99,98%-тай ажилласан.

САНГИЙН ТӨРӨЛ	ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ сая төгрөг	ГҮЙЦЭТГЭЛ сая төгрөг	ХЭМНЭЛТ/ХЭТРЭЛТ ХУВЬ
ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН	238,424,1	238,400.0	99,99%
ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН	15,313.4	15,300.0	99,91%
ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САН	1,424.6	1,420.0	99,68%
АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН	14,655.7	14,655.7	100%
НИЙТ	269,817.80	269,775.7	99,98%

**Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах,
шилжүүлэх журмын хэрэгжилтийг хангаж ажилласан ажлын талаар**

- Газрын даргын 2026 оны 05 сарын 29-ны өдрийн А/22 тоот тушаалын дагуу 2026 оны хагас жилийн тооллогыг зохион байгуулахад нийт 1,948,608.4 мянган төгрөгийн хөрөнгийг тоолж илүүдэж дутагдсан хөрөнгө байхгүй тайланг НДЕГ-т хүргүүлэн ажилласан.
- Нийгмийн даатгалын ерөнхий газарт хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглах хугацаа сунгах, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалтад 16 нэр төрлийн 73,493.2 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмж 14ш, тавилга эд хогшил 17 ш нийтийн эзэмшлийн 1ш хөрөнгүүдийг актлуулах саналыг хүргүүлсэн.
- Худалдан авах төлөвлөгөөгөө батлуулан худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим системд оруулж нийтэд нээлттэй мэдээлсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 05 сарын 13-ны А/136 тоот тушаал Урсгал үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн хуваарийн дагуу байр ашиглалт 13,927.6 мянган төгрөг, бичиг хэргийн 2,995.5 мянган төгрөгийн зардлыг гэрээний дагуу сангийн хөрөнгийг хамгийн бага зардлаар, хамгийн чанартай бараа үйлчилгээ худалдан авалтыг зохион байгуулан ажилласан.

БУСАД АЖИЛ:

- Нийгмийн даатгалын багц хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Журам, аргачлал батлах тухай” А/72 тушаалаар баталсан “Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, төсвийн нарийвчилсан хуваарь батлах, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахад баримтлах журам”, “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлал”, 2026 оны “Аргачлал, маягт батлах тухай” А/145 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлалын дагуу төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, нэгтгэх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг Газрын даргын 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/23 тоот тушаалаар зохион байгуулж ажилласан. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2027 оны төсөл, 2028-2029 оны дунд хугацааны төсөөллийг боловсруулан хамт олны хурлаар хэлэлцүүлэн саналыг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.
- Shilengans.gov.mn сайтад 2026 онд үйл ажиллагааны орлого зардлын шилэн дансны мэдээллийг цахим системд тухай бүр, хуулийн хугацаанд тайлагнаж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 171 мэдээллийн 5 бүлэг 29 зүйлийн мэдээллийг байгууллагын нягтлан бодогч, нийгмийн даатгалын сангийн 159 мэдээллийн 5 бүлэг 28 зүйлийн мэдээллийг сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтнүүд 7 хоног, сар, улирал, жилээр мэдээллийг байршуулж газрын даргын тушаалаар ахлах нягтлан бодогч болон хяналт шалгалтын байцаагч байнгын хяналт тавин ажиллаж байна.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2026
ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

- Байгууллагын нээлттэй www.shilen.gov.mn мэдээллийн сайттай холбон 1 дүгээр улирлын 5 бүлгийн 48 үзүүлэлтийг байршуулан 91% үнэлгээ авсан бөгөөд 2 дугаар улирлын мэдээллийг бүрэн байршуулсан. Байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг 2025 оны жилийн эцсийн байдлаар www.Shilendans.gov.mn сайтад дөрвөн улирал тус бүрээр нийт 56 мэдээллийг ил тод болгон ажилласан.
- <https://info.shilen.gov.mn> сайтад Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж 1 дүгээр улирлын байдлаар 91 хувьтай дүгнэгдэж цаашид алдаа гаргахгүй ажиллахаар шилэн данс хариуцсан байцаагч ажилтнууд дотооддоо мэдээлэл алдаа оноогоо дүгнэн хариуцлагатай ажиллаж байна.
- 2026 оны нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны санхүүгийн тайланд Гэрэлтэх бүртгэл аудит ХХК аудитын шалгалт хийгдсэний дагуу зөвлөмжийн биелэлтийг 63 хувь биелүүлэн НДЕГ-ын Дотоод аудитын, мониторингийн газарт хүргүүлэн ажиллалаа.

ТЭТГЭВЭР ОЛГОЛТЫН ТАЛААР

Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 38341 тэтгэвэр авагч нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, ҮОМШӨТТТухай хууль болон цэргийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр авч байна. Үүнээс:



2026 оны эхний хагас жилийн байдлаар:

- ✓ Нас барсны дараа сарын олголтыг 320 тэтгэвэр авагч,
- ✓ Ажилласан жилийн нэмэгдэл, цалин өөрчлөлт хийсэн 583 гаруй даатгуулагчийн олголт,
- ✓ Шинээр тогтоон, олгож байгаа 1085
- ✓ Группийн сунгалт хийлгэсэн 664 тэтгэвэр авагчийн файлыг жагсаалтаар,

Нийтдээ 236.436.379.944 төгрөгийг арилжааны 5 банкаар дамжуулан цаг хугацаанд нь олгосон байна.

Тайлант хугацаанд нийт шинээр 1085 тэтгэвэр авагчийн материалыг анхан шатанд хянаж, шалгаж мэдээллийн баазад оруулан тогтоон ажилласан байна. Үүнээс:



Мөн тухайн онд шилжиж ирсэн болон явсан эрхийн харилцаа дуусгавар болсон нийт 609 тэтгэвэр авагчийн хөдөлгөөнийг программд хийсэн байна. Үүнд:

- Шилжиж явсан - 15
- Шилжин ирсэн - 18
- Нас барсан - 320
- Зогсоогдсон буюу эрхийн харилцаа дуусгавар болсон - 256

Тэтгэвэрт гарснаас хойш ажилласан 443 тэтгэвэр авагчийн тэтгэврийн өөрчлөлтийг мэдээллийн баазад хийж хуулийн хугацаанд нь олгосон.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны талаар

Газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2026 оны 1 дүгээр сард эмнэлгийн хуудас шалгах дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар эрүүл мэндийн 7 дугаар төвд мэдрэл болон гэмтлийн эмнэлгийн хуудас бичиж олгосон жагсаалтад хяналт үнэлгээг хийж хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 1/07 дугаартай албан бичгийн дагуу хугацаагүй сунгалттай хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийг дахин магадлалд хамруулах ажлыг зохион байгуулан 495 иргэний өвчний картыг хамруулсан. 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 1/11 дугаартай хамтарсан магадлал зохион байгуулах албан бичгийн дагуу 1466 иргэний картыг шалгуулах ажлыг зохион байгуулсан. Тус арга хэмжээг Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм-ийн 12,3 дахь заалтыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар 2026 оны 04 дүгээр сарын 01-12-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан. Хамтарсан магадлалаар нийт 1254 иргэнийг дахин магадлалд хамруулсан.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ

“Тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийж, олголт шалгах” хяналт шалгалтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар

Газрын даргын 2026.01.22-ны өдрийн №04 тоот “Тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийж, олголт шалгах” удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хувийн хэргийн тооллого явуулж, шилжсэн, нас барсан, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг хянан шалгах, хадгаламжийн нэгж болгон архивд шилжүүлэх ажлыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, таслан зогсоох, залруулах, урьдчилан сэргийлэх, байцаагч албан хаагчдын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллах зорилгоор 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хугацаанд дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллого хийж, олголт шалгах ажлын хүрээнд нийт 37354 тэтгэврийн хувийн хэрэг тоологдохоос 37351 хувийн хэрэг тоологдсон. Тооллогоор 3 хувийн хэрэг дутуу тоологдсон тул 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 01 тоот Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн ажилласан. Дутуу тоологдсон хувийн хэргийг олж тооллогод бүрэн хамруулсан.

Шалгалтаар 2025 онд шилжсэн, нас барсан, зогсоогдсон нийт 1197 тэтгэвэр авагчдын олголтыг мэдээллийн сан болон анхан шатны баримтад үндэслэн шалгаж, хувийн хэргийг массивын дараалалд оруулан хадгаламжийн нэгж болгон архивд шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Шалгалтаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 (Өндөр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш гаргасан бол өргөдлийг нийгмийн даатгалын байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн нас барсны дараагийн сарыг дуустал олгоно.) дэх заалтыг зөрчиж нас барсан 13 иргэнд 11,415,428 төгрөгийн тэтгэврийг илүү, 7 иргэнд нас барсны дараа сарын 5,278,123 төгрөгийн тэтгэврийг дутуу олгосон зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын байцаагчийн 25/00074, 25/00075 тоот акт тогтоон шийдвэрлэсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.5 (тэтгэвэр авагч өөр төрлийн тэтгэврийг сонгосон тохиолдолд шинээр тогтоолгосон тэтгэврийг олгож эхэлсэн өдрөөс) дахь тэтгэвэр олголтыг зогсоох заалтыг зөрчиж 18 даатгуулагчид 5,754,015 төгрөгийн тэтгэврийг илүү, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1 (Энэ хуулийн 24.1.1-д заасны дагуу түдгэлзүүлсэн тэтгэврийг эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр гарсан өдрөөс) дэх зогсоох заалтыг зөрчиж 36 даатгуулагчид 10,132,436 төгрөгийн тэтгэврийг дутуу олгосон зөрчил илэрсэн.

Илэрсэн зөрчилд 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын байцаагчийн 25/00076 тоот акт, 03 дугаар сарын 30-ны өдөр 25/00077 тоот актуудыг тогтоож шийдвэрлэсэн.

Тэтгэврийн тогтоолт, олголтод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, хэрэгжүүлсэн ажлын талаар

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5² дугаар зүйлийн 5^{2.1} дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.4 дэх, 37 дугаар зүйлийн 37.13.2 дахь заалт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” А/82 тоот албан бичиг, хяналт шалгалтын нэгдсэн удирдамжийг тус тус үндэслэн Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах дотоодын хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар: Тэтгэврийн олголтод 2020-2025 онд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн судалгааг гаргаж, улсын байцаагчийн актын барагдуулалт, авсан арга хэмжээ, биелэлтийн үндэслэлийг тулган шалгах,

Тэтгэвэр авах эрх зүйн харилцаа дуусгавар болж нас барсан, зогсоогдсон болон шилжин явсан, шилжин ирсэн, Монгол Улсын иргэний харьяатаас гарсан, гадаад улсын иргэн тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтын тооцооллын үндэслэлийг тулгах шалгах,

Мэдээллийн технологийн төвөөс ирүүлсэн 2020-2025 онд нас барсны дараа сараас хойш илүү олгогдсон зөрчилтэй тэтгэврийн жагсаалтад үндэслэн тэтгэврийн олголтыг тулган шалгаж, батлагдсан хүснэгтийн дагуу судалгаа гаргах,

Тухайн сар, улиралд тэтгэвэр олголтын файл, жагсаалтаар болон олголтын хуудсаар 2020-2023 онд олгосон тэтгэврийн дүнг холбогдох сангийн харилцах данснаас олгосон тэтгэврийн тухайн сар, улирлын нэгдсэн дүнтэй тулган шалгах, зэрэг хяналт шалгалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Шалгалтаар: 2020-2025 онд нас барсны дараа сараас хойш илүү олгогдсон зөрчилтэй тэтгэврийн жагсаалтыг мэдээллийн “sicos программ болон холбогдох баримт материалд үндэслэн шалгахад 17 хүнд 78.329.497 төгрөгийн тэтгэврийг илүү олгосон зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож шийдвэрлэсэн.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 24.2.3 дахь заалтыг зөрчиж Монгол Улсын иргэний харьяатаас гарсан, гадаад улсын иргэн болсон 2 тэтгэвэр авагчид 27.402.400 төгрөгийн тэтгэврийг илүү олгосон зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож шийдвэрлэсэн. Улсын байцаагчийн актын биелэлтийг хангаж, илүү олгосон тэтгэврийг буцаан төлүүлж тэтгэврийн даатгалын санг хохиролгүй болгож ажиллахыг ТТХ-ийн холбогдох албан хаагчдад үүрэг болгон ажиллаж байна.

Ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолт, олголтод хяналт шалгалт хийж, хэрэгжүүлсэн ажлын талаар

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Ажилгүйдлийн тэтгэмж шалгах тухай” А/69 тоот албан бичиг, хяналт шалгалтын нэгдсэн удирдамжийн дагуу 2024-2025 онд олгосон Ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолт, олголтод дотоодын хяналт шалгалтын ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн ажлын 22 хоногийн хугацаанд зохион байгуулсан.

Тус газар нь 2024 онд 3307 даатгуулагчид 17,9 тэрбум, 2025 онд 3969 даатгуулагчид 24,3 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг олгосон байна.

Тэтгэмжийн тогтоолт, олголтыг мэдээллийн “SICOC” системд үндэслэн шалгахад 2024 онд 422 даатгуулагч, 2025 онд 718 даатгуулагч тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж албан журмын даатгалд хамрагдсан байх магадлалтай нөхцөл байдал тогтоогдсон. Иймд тушаалын хуулбар авч илүү, дутуу олгосон төлбөр зөрчлийн тооцооллыг гаргаж 2024 онд 82 даатгуулагчид илүү олгосон 130,859,712 сая төгрөгийг буцааж төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоосон. 2026 оны эхний хагас жилийн байдлаар 104,018,997 төгрөгийг барагдуулан ажиллаад байна. 2024 онд ахин тодруулах шаардлагатай 340, 2025 онд 718

даатгуулагчдын тушаал шийдвэрийг авч зөрүүг тооцож нийгмийн даатгалын санг хохиролгүй болгох ажил хийгдэж байна.


Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт шалгалт, дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажилласан.

Зөрчлийн тухай хуулийг хэрэгжилтийг хангаж ажилласан талаар

Зөрчлийн тухай хуулийн 10.17.2, 10.17.3, 10.17.5, 10.17.8, 10.17.9, дугаар заалтын дагуу хялбаржуулсан журмаар 108 аж ахуй нэгж байгууллагад 100,350,000 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж БГД-н Прокурорын нэгдсэн бүртгэлд хугацаанд нь бүртгүүлж торгуулийг бүрэн барагдуулсан.

Аж ахуй нэгж байгууллага, иргэд даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу хийсэн хяналт шалгалтын талаар

2026 оны эхний хагас жилийн байдлаар 239 ААНБ-аас ирүүлсэн албан бичиг, өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. 239 ААНБ-ын 1,365,739,411 тэрбум төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос 134,621,400 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, 40,491,238 сая төгрөгийн алданги ногдуулж, нийт 175,112,639 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож төлбөр зөрчлийг 100 хувь барагдуулан ажилласан.



ХАМРАЛТ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ

Тус газар нь 2026 оны эхний хагас жилд 296,4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 300,9 тэрбум төгрөгийг өр төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 101.5 хувиар биелүүлсэн.



Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2026 оныг “Ёс зүй, сахилга, хариуцлага, хяналт бүтээмжийг дээшлүүлэх” жил болгон зарласантай холбоотойгоор тайлант хугацаанд нийгмийн даатгалд шинээр 450 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг сар бүр хүлээж авч тооцоог тухай бүр хийж, албан журмын даатгалд 994 даатгуулагчдыг шинээр хамруулан ажиллаж байна. Хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын фейсбүүк пэйж хуудас болон Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын Хамралт, орлогын хэлтсийн ААН байгууллагуудын нэгдсэн фейсбүүк групп хуудсаар дамжуулан хуулийг сурталчлан таниулж ажилласан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 тушаалаар батлагдсан журмын дагуу өр авлагыг насжилтаар нь ангилан барагдуулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. 43 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, 115 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлж, 64 аж ахуй нэгж байгууллагатай өр, авлага барагдуулах гэрээ байгуулж, 4 аж ахуй нэгж байгууллагыг шүүхэд шилжүүлэх арга хэмжээнүүдийг авч ажилласан.

2026 оны эхний авлага 86,4 тэрбум төгрөгөөс 40,3 тэрбум төгрөгийн авлага буюу 46,7 хувийг барагдуулан ажиллаж байна.




Шүүхийн шийдвэр:

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлд заасан ажил олгогчийн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн өр, түүнээс үүссэн алдангийг барагдуулах чиглэлээр тус газраас харьяалах шүүхэд 2026 онд давхардсан тоогоор 14 аж ахуйн нэгжид холбогдуулан нэхэмжлэл гаргасан.

Сайн дурын даатгал:

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2026 оныг “Ёс зүй, сахилга, хариуцлага, хяналт бүтээмжийг дээшлүүлэх” жил болгон зарласантай холбоотойгоор тухайн онд сайн дурын даатгалд гэрээ сунгалт болон шинээр бүртгүүлсэн 1453 даатгуулагч гэрээ байгуулсан.



СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Дотоод сургалт

Тайлант хугацаанд албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага болон эрүүл мэндийн боловсролыг дэмжих зорилгоор нийт 40 удаагийн дотоод болон цахим сургалтад давхардсан тоогоор 1245 албан хаагчдыг хамруулан ажиллалаа.

Газрын хэмжээнд нийт 26 удаагийн сургалт, мэдээллийг үе шаттайгаар зохион байгуулж албан хаагч, ажилтнуудыг бүрэн хамруулсан. **Үүнд:**

- Төрийн албан хаагчийн ёс зүй;
- Ажлын байран дахь стресс, түүнийг даван туулах арга зам;
- Хамт олны харилцаа, хандлага;
- Жендерийн тэгш оролцоо, хүний эрхийн тухай хууль;
- Эрүүл мэнд ба идэвхтэй хөдөлгөөн;
- Амьсгалын дасгал болон алхалтын ач холбогдол;
- Архив, албан хэрэг хөтлөлт;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, тэтгэврийн тусгай зохицуулалт, тэтгэвэр бодох аргачлал;
- Улсын байцаагчийн шалгалтад хамрагдах албан хаагчдыг чадавхжуулах сургалт;
- Долоо хоног бүрийн пүрэв гарагийг албан хаагч, ажилтнуудын ажлын байрны мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, харилцан туршлага солилцох, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Мэдэллийн цаг” ийн сургалт, мэдээллийг тогтмол зохион байгуулан ажилласан.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2026
ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Мөн долоо хоног бүрийн баасан гарагт Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан “Мэдээллийн цаг”-ийн 14 удаагийн сургалтад албан хаагч, ажилтнуудыг тогтмол хамруулж, хууль, эрх зүйн шинэчлэл, бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг шуурхай хүргэн, газрын үйл ажиллагаанд үр дүнтэй хэрэгжүүлэх мэдлэг, чадавхыг бэхжүүлэхэд анхааран ажиллалаа.



Гадаад сургалт

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2026
ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Тус дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 800 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, үйлчилгээний салбарын төлөөлөл оролцсон “Баянгол дүүргийн бизнес эрхлэгчдийн нэгдсэн форум 2026” арга хэмжээнд тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгал, хяналт шалгалтын байцаагчид оролцож Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.

Баянгол дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг томоохон зах, худалдааны төвүүдэд ажиллан хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдэд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулж хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан. Жишээ нь “Maxmall” худалдааны төв, “5-н эрдэнэ” хүнсний зах, “1000,10000” нэрийн худалдааны төв, “Мандах” ДС, “Барилгын технологийн коллеж” зэрэг газруудад хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нэг цэгийн үйлчилгээний өдөрлөгийг зохион байгуулсан.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, байгаль орчноо хамгаалах болон байгууллагын нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх зорилгоор мод тарих үйл ажиллагаанд хамт олноороо оролцсон.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР